



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: МУИС-ийн Бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: “Маркетинг” магистрын сургалтын хөтөлбөр

Индекс: E04140101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Наранчимэг

Гишүүд: Дам.Ганбаатар
Даян.Ганбаатар

Улаанбаатар хот

2020 оны 12 сарын 30-ны өдөр

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

МУИС	- Монгол Улсын Их сургууль
БС	- Бизнесийн сургууль
СЭЗИС	- Санхүү Эдийн Засгийн Их сургууль
ХМСТ	- Хэрэглээний математик, статистикийн тэнхим
ШУТИС	- Шинжлэх Ухаан Техникийн Их сургууль
ХНХЯ	- Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам
ИДС	- Их дээд сургууль
ХЧБХ	- Хөтөлбөрийн чанарын баталгаажилтын хэлтэс
ӨҮТ	- Өөрийн үнэлгээний тайлан
ОТХ	- Оюутан төгсөгчдийн хэлтэс
ХААИС	- Хөдөө Аж Ахуйн Их сургууль
ЭЗБС	- Эдийн засаг бизнесийн сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС, Бизнесийн сургууль National University of Mongolia, School of Business	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Маркетинг Marketing	
Индекс	E04140101	
Шинжээчид	Шинжээчийн багийн ахлагч: 1. Ч.Наранчимэг (СЭЗИС-ийн ХМСТ-ийн профессор, PhD) Шинжээчийн багийн гишүүд: 2. Дам.Ганбаатар (Удирдлагын Академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн профессор, PhD) 3. Даян.Ганбаатар (ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн дэд захирал, дэд профессор, PhD)	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн Г.Даваажаргал (дэд профессор, PhD)	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2020/12/03	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг цахимаар хүлээлгэн өгнө.
	2020/12/11	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020/12/21, 22	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2020/12/30	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020/12/31	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетинг магистрын хөтөлбөр нь тухайн үеийн ШУБ-ын сайдын 1996 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 84-р тушаалаар олгосон тусгай зөвшөөрлийн дагуу 1996 оноос сургалт явуулж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэж, хөтөлбөрийн шинэчлэлийг тасралтгүй хийж ирсэн ба “Онолын мэдлэг, туршилт судалгааны ур чадвар, арга барил, мэргэжлийн болон нийгмийн чадварыг эзэмшсэн, глобал ертөнцөд өрсөлдөх чадвар бүхий судлаач, бэлтгэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн нэгж нь 60 гаруй жилийн түүхтэй Маркетинг худалдааны тэнхим юм. Маркетингийн магистрын сургалт нь мэргэжлийн болон судалгааны гэсэн хоёр чиглэлтэй ба судалгааны магистрын хөтөлбөр нь 30 багц цаг, мэргэжлийн магистрын хөтөлбөр нь 32 багц цагаар төлөвлөгдсөн. Энэ нь одоо мөрдөгдөж буй БШУС-ын А/370 тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам” болон МУИС-ийн сургалтын журамтай нийцэж байх бөгөөд сүүлийн 5 хичээлийн жил нийтдээ 41 магистрант төгссөн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хичээлийн хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Гадаад, дотоодын ижил хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага
- МУИС-ийн сургалтын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

(Тэмдэглэл: ӨҮ-ний баг “хэсэгчлэн хангасан” гэсэн үнэлгээ өгсөн.)

Онцлог зүйл/Туршлага:

- ХНХЯамны Ажиллах хүчний барометрийн судалгааг ашигладаг.
- Гадаадын их дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан.
- Ижил төстэй хичээлүүдийн харьцуулсан судалгаанд суурилан хичээлүүдийг бусад ИДС-ийн суралцагчдад нээлттэй болгоход шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагын судалгааг тогтмол хийж хэвших.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөр тасралтгүй сайжрах тогтолцоог бий болгох. Үүний тулд хэрэгцээг зөв тодорхойлох механизмтай болох;
- Өөр мэргэжлийн оюутан тус хөтөлбөрөөр суралцахаар элссэн тохиолдолд маркетингийн суурь ойлголт олгох хичээлийг урьдчилан судлах боломжийг олгосон сургалтын журмын заалтыг хэрэгжүүлэх;

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн эрхэм зорилго
- Хөтөлбөрийн зорилго
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилгыг байгууллага, үндсэн сургууль, нэгж хэсгийн эрхэм зорилготой уялдуулан тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгыг 2014-2015 оны хичээлийн жилд шинэчилсэн. Шинэчлэх болон шинэчлэлийн талаар оролцогч талуудад мэдээлээгүй.
- Төгсөгчдийн ур чадварыг тодорхойлох судалгаа хийгддэггүй.

Зөвлөмж:

- Ажил олгогчдоос төгсөгчдийн ур чадварыг тодорхойлох судалгаа авч, үр дүнг хөтөлбөрт тусгах, улмаар энэ үйл явцыг тогтмолжуулж хэвшмэл үйл ажиллагаа болгох

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөр
- МУИС болон БС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн шинэчлэл хийгдсэн. /2012 оны хөтөлбөрийг 2015.07.01 шинэчилсэн./
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж буюу тэнхим “Заах арга зүйн зөвлөл”-тэй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлд ажил олгогчийн санал тусгагдаагүй.

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим дээр тэнхимийн хичээлүүдээс бусад хичээлийн хөтөлбөр байхгүй байгааг анхаарах /Жич: МУИС-ийн ХЧБХ-ээс авчруулж хичээлийн хөтөлбөрүүдтэй танилцсан./

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүрээнд ордог бүх хичээлийн хөтөлбөрөөр электрон эсвэл хэвлэмэл хэлбэрээр “Хичээлийн хөтөлбөрийн тэнхимийн сан” бүрдүүлэх

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө
- Маркетинг магистрын хөтөлбөрийн үр дүнгийн матриц
- Маркетинг магистрын хөтөлбөрийн хичээлийн агуулга, үнэлгээний хүснэгт
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Бакалавр, магистрын хөтөлбөрийн хичээлүүдийн уялдаа холбоог тодорхойлсон.
- Магистрын эзэмших мэдлэг, ур чадварыг академик компетенц, судалгааны компетенц, ерөнхий компетенц гэсэн ангиллаар хичээл бүр дээр дэлгэрэнгүй тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тэнхимийн хичээл бүрээр идэвхтэй сургалтын аргуудыг ашигладаг байдлыг тодорхойлсон хүснэгт
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Идэвхтэй сургалтын 11 аргыг ашигладаг.
- Сургалтын арга зүйг боловсронгуй болгох сургалт зохион байгуулдаг. /ӨҮТ-ийн хүснэгт 2.6/
- SPSS, SMART PLS зэрэг программыг сургалтандаа ашигладаг.
- МУИС-ийн төв номын сангийн байранд байрладаг БС-ийн дадлагын бааз буюу Нийгмийн судалгааны хүрээлэн, Дата лаборатори нь албан ёсны лицензтэй программ ашигладаг бөгөөд Маркетинг магистрын хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад судалгаа шинжилгээ хийх нөхцөл боломжоор дэмжин тусалдаг.

Анхаарах асуудал:

- Хичээлийн төлөвлөгөө бүрд тухайн хичээлээр ашиглах программ хангамж тусгагдаагүй.

Зөвлөмж:

- Тухайн хичээлд ашиглах программуудын жагсаалтыг гаргаж, хичээлийн хөтөлбөрт тусгах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн төлөвлөгөө
- Хичээлийн агуулга, үнэлгээний хүснэгт
- Дадлагын удирдамж
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Маркетинг магистрын хөтөлбөрийн хичээлийн агуулга, үнэлгээний хүснэгт хийсэн.
- Хичээл бүрийн төлөвлөгөөнд 100 онооны задаргаа тусгагдсан.
- Суралцагчийн үнэлгээний шалгуур арга зүй тодорхой, ойлгомжтой

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын 5 лаборатори болон хичээллэх анги танхим нь стандартад нийцсэн.
- Сургалтын орчны судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчны судалгаа тогтмол хийгддэг.
- Номын санд суух бололцоо сайн, сэтгэл ханамжтай байх нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн.
- Хичээлийн анги танхим хангалттай. Анги бүр проектор болон суурин компьютертой.
- 5 лабораторитой.
- Хичээлийн 4-р байр шинэчлэгдэж, шинээр баригдахаар төлөвлөгдөж байгаа.

Анхаарах асуудал:

- Суралцагч болон төгсөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр ангийн орчин тааруу, WIFI-ний хурд муу, зарим ангийн проектор муу тусдаг гэсэн шүүмж гарсныг цаашид анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Сургалтын онцлогт нийцсэн, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн анги танхимын загварыг гаргаж шинээр баригдахаар төлөвлөж байгаа байрны зураг төсөлд эртнээс тусгах, анги танхим лабораторийн орчныг олон улсын жишиг, орчин үетэй нийцүүлэх тал дээр анхаарах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл явцаа СиСи удирдлагын мэдээллийн системээр дэмжиж өгдөг. Тус системээр дамжин сургалтын орчны үзүүлэлтээ нэгтгэж гаргадаг.

- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаан дээр сургалтын орчны талаар бүлэг үзүүлэлт байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сургалтын төв шинээр байгуулагдсан. Цахим сургалтын төвтэй болсноор сургалтын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.
- Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа тогтмол хийгддэг.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар удирдамжийг вэб сайтад байрлуулдаг.
- МУИС-ийн төв номын сангийн байранд байрладаг БС-ийн дадлагын бааз буюу Нийгмийн судалгааны хүрээлэн, Дата лаборатори нь судалгааны лицензтэй программтай.

Анхаарах асуудал:

- Хичээлийн төлөвлөгөө бүрд тухайн хичээлээр ашиглах программ хангамж тусгагдаагүй.

Зөвлөмж:

- МУИС-ийн төв номын сангийн байранд байрладаг БС-ийн дадлагын бааз буюу Нийгмийн судалгааны хүрээлэн, Дата лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлэх, боломжтой бол шинээр баригдах хичээлийн 4-р байранд орчин үеийн маркетингийн чиглэлийн бие даасан судалгааны лабораторитой болох

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш бүрээс шаардлагатай тоног төхөөрөмж, ном, программ хангамжийн талаар авсан судалгаа
- Сурах бичгийн судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жилд нэг удаа тэнхимийн эрхлэгч багш нараас шаардлагатай номын жагсаалтыг авдаг. Тэнхим нэгтгэн, шаардлагатай номыг захиалан авдаг тогтолцоо бүрдсэн.
- Сүлжээгээр дамжин мэргэжлийн нэгдсэн санд холбогдсон, бусад номын сантай чөлөөтэй харилцах, хандах нөхцөл бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Магистрын түвшинд ашиглах монгол хэл дээрх сурах бичиг цөөн.

Зөвлөмж:

- Сургалтад ашигладаг монгол сурах бичгийн тоог нэмэгдүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн болон БС-ийн Хөтөлбөрийн хороо хурлын тэмдэглэл, шийдвэр
- Хөтөлбөрийн эрх зүйн баримт бичгүүд болон хэрэгжүүлэлттэй холбоотой холбогдох дүрэм журам
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн тайлан, төлөвлөгөө
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь “МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2016-2024” баримт бичигтэй уялдаатай боловсруулагдаж, хэрэгждэг. Түүнээс гадна багшийн хувийн төлөвлөгөө, саналыг тусгадаг тогтолцоо бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Сургалтын чанарыг сайжруулах үйл явцад ажил олгогч талын оролцоо сул.

Зөвлөмж:

- Сургалтын чанарыг сайжруулах үйл явцад ажил олгогч талын оролцоог нэмэгдүүлэх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын оролцсон төсөл, гэрээт ажлуудын мэдээлэл
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран ажилладаг айлчлан ирсэн зочид төлөөлөгчийн жагсаалт, үр дүнгийн мэдээлэл
- Маркетингийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа, хамтран ажилласан байгууллагын жагсаалт, зардлын эх үүсвэр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш солилцооны хөтөлбөр хэрэгждэг.
- Тэнхимийн багш нар байгууллагуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат судалгааны ажил хийх, зөвлөхөөр ажиллах зэргээр нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд хангалттай оролцдог. /ӨҮТ-ийн хүснэгт 4.6/
- Маркетинг магистрын хөтөлбөрт хичээл заадаг доктор багш нар нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн. Тухайлбал, гадаад болон дотоодын мэргэжлийн холбоодод гишүүнчлэлттэй, мэргэжлийн сэтгүүлийн редакцын зөвлөл, хамгаалуулах зөвлөлд сонгогдон ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа идэвхтэй бус.
- Сүүлийн 5 жил тэтгэлэгт хамрагдсан суралцагч байхгүй байна.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, үр дүн, хамрагдсан хүмүүсийн тоо зэргийг тусгасан мэдээллийн сан бүрдээгүй.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;
- Тэнхимийн мэдээллийн сан буюу дата санг бүрдүүлэх. Тухайлбал, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, үр дүн, хамрагдсан хүний тоо зэргийг тухай бүр бүртгэлжүүлж хэвших;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Санхүү төлөвлөлтийн газрын мэдээллийн линк

- Төсвийн зарцуулалт, орлого бүрдэлт, төсвийн зарцуулалтын холбогдох дүрэм журам, санхүүгийн албаны баримт, тайлан, нэгтгэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хэмжээнд “Шилэн данс”-тай.
- Төсвийн зарцуулалтын журамтай. Уг журмаа хатуу мөрдөж ажилладаг.
- Сургуулийн төсвийг боловсруулахдаа тэнхим буюу анхан шатны нэгжийн төсвийн саналд үндэслэдэг тогтолцоо бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Тэнхим буюу анхан шатны нэгжийн төсвийн саналын нийт дүн, батлагдсан дүн, гүйцэтгэлийн дүн нэгтгэгдээгүй, дүн шинжилгээ хийгддэггүй.

Зөвлөмж:

- Төсөвтэй холбоотой тэнхимийн мэдээллийн сан буюу дата санг бүрдүүлэх. Үүнд: төсвийн саналын бүрдэл, түүний нийт дүн, батлагдсан төсөв, түүний нийт дүн, гүйцэтгэлийн задаргаа, түүний нийт дүн зэргээр дата сан бүрдүүлэх, тодорхой хугацаанд дата сангаа баяжуулдаг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох;
- Алба нэгжийн удирдлага төсвийн санал, батлагдсан төсөв, гүйцэтгэл зэрэгт тайлант хугацаа бүр дүн шинжилгээ хийдэг, санхүүгийн төлөвлөлтийн үр дүнгээ үнэлдэг болох;

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн вэб хуудас, холбогдох линк
- 2018 онд боловсруулсан “МУИС-ийн маркетингийн төлөвлөгөө”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Маркетингийн идэвхжүүлэлтийг МУИС-ийн “Хөтөлбөр чанарын баталгаажуулалтын алба” хариуцан нэгдсэн байдлаар зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн вэб хуудас, холбоосууд
- СиСи удирдлагын мэдээллийн систем
- Фэйсбүүк групп

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Вэб хөгжүүлэлт, мэдээлэл шинэчлэх үйл ажиллагаа тогтмолжсон.
- Орчин үеийн бүхий л мэдээлэл хүргэх сувгийг ашигладаг.
- Тэнхимийн мэдээллийн самбар ажиллуулдаг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Нэг цэгийн үйлчилгээг 2017 оны 4-р улирлаас нэвтрүүлсэн.
- Шинээр элссэн суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг.
- Магистрантуудад зөвлөх багш нарыг томилон, зөвлөх багш нараар дамжуулан мэдээлэл өгдөг.

Анхаарах асуудал:

- “МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2016-2024” -нд тусгагдсан гадаад суралцагчийн тоог нийт суралцагчийн 10%-д хүргэх зорилтын хэрэгжилт сул.

Зөвлөмж:

- байхгүй

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн ярилцлага
- МУИС-ийн вэб хуудас, цахим холбоос

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр хуваарийн дагуу тогтмол, долоо хоногт 2 цагийн зөвлөгөө өгдөг.
- Судалгааны семинар 7 хоног бүрийн лхагва гарагт 17 цагаас дугуй зааланд болдог.
- Магистрант, докторантаа сонсьё хэлэлцүүлэг явагддаг.
- Хувь хүний хөгжлийн лекц тогтмол зохион байгуулагддаг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантыг захиргааны, судалгааны, сургалтын гэсэн 3 төрлийн туслахаар ажиллуулдаг.
- Магистрантаа эрдэм шинжилгээний хуралд оролцуулах байдлаар хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сүүлийн 5 жилд тус хөтөлбөрийн магистрантуудаас тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн магистрантуудаас сүүлийн жилүүдэд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй шалтгааныг тодруулах, улмаар тэтгэлэгт хамрагдах боломж нөхцөлийг судлан, мэдээллийн хүртээмжийг сайжруулах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам
- Бүртгэлийн албанаас гаргасан шилжилт хөдөлгөөний дүн мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургууль дотроо, бусад их дээд сургууль руу, бусад их дээд сургуулиас шилжин суралцах боломжтой.
- Шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь окуутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн сургалтын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн бичиг баримтын эх хувийг цахим хэлбэрээр шалгах боломжтой.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр 2019-2024
- Ахисан түвшинд хичээл зааж байгаа багшид ноогдох магистрантын судалгаа /сүүлийн 6 жил/
- Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь судалгаа /сүүлийн 6 жил/
- Багшийн албан тушаалын зэрэглэл, цалингийн сүлжээний судалгаа
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгогдсон урамшууллын судалгаа
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага
- Багшийн сонгон шалгаруулалтын баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нараа эрдэмжүүлэх ажил шат дараатай хэрэгжиж байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын 50% нь доктор зэрэгтэй, үлдсэн 50% нь докторант багш байна.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрт хичээл ордог доктор багш нарын ачаалал их.

Зөвлөмж:

- Багш нарын ачааллыг бууруулах, хүний нөөцийн талаарх асуудлыг бодлогын түвшинд анхаарч, хэрхэн шийдэх гарц шийдлийг үе шаттайгаар тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш гадаад дотоодод мэргэжил дээшлүүлсэн, багшийг чадавхжуулсан талаарх судалгаа
- Багшийн хөгжлийг хангах хэрэгцээний дагуу хийсэн ажлын тайлан
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага
- Сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 115 удаа урт, богино хугацааны сургалтад хамрагдсан талаарх мэдээлэл, судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг “судалгааны цогц чадамж хөгжүүлэх”, “сургалтын цогц чадамж хөгжүүлэх”, “хувь хүний чадамжийг хөгжүүлэх” гэсэн чиглэлээр нарийн ангилж, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрт нийгмийн баталгааг хангах (орон сууц, хангамж) чиглэлийн арга хэмжээнүүд тусгагдаагүй.
- Багш нарын ачаалал ихээхэн хамаарч хөтөлбөрийн үр дүн болон чанарт сөрөг нөлөө учирч болзошгүй тул хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийг шинэ багш нараар өргөжүүлэх ажлыг зохион байгуулахад анхаарах.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрт нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг тусгаж, шинэчлэн боловсруулах саналыг холбогдох алба нэгжид хүргэх.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Нийтлэгдсэн бүтээл, өгүүллүүд, эмхэтгэл
- Багш нарын туурвисан ном, сурах бичиг, гарын авлага
- Багш нарын нийтлүүлсэн ЭШ-ний өгүүлэл, хэвлүүлсэн илтгэлийн тоон судалгаа /ӨҮТ-ийн хүснэгт 6.9/
- Багш нарын оролцсон төсөл, гэрээт ажлуудын жагсаалт / ӨҮТ-ийн хүснэгт 6.10/
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага
- МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд МУИС-ийн 30 сая төгрөгний өртөгтэй судалгааны ажлыг авч хэрэгжүүлсэн.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж буй санхүүжилт нэмэгдсэн.
- Судалгааны санхүүжилтийн журамтай.
- Судалгааны санхүүжилтийг профессор багш нарт болон докторын зэрэгтэй залуу багш нарт суурь зардал хэлбэрээр олгодог.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн ажлын дэвтэр
- МУИС-ийн Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний журам
- СиСи системээр авдаг суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, судалгааны үр дүн
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн ажлыг үнэлэх тогтолцоо бүрдсэн.
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ хийгддэг.
- Суралцагчдаас багшийн ажилд өгдөг үнэлгээ, тодорхой шалгууруудтай. / ӨҮТ-ийн хуудас 124/

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын бие даасан бүтэцтэй. (ХЧБХ-хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс)
- Батлагдсан журмын дагуу хийсэн ажлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Чанарын алба байгуулагдаж, хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийж хэвшсэн.
- МУИС-ийн хэмжээнд мөрдөгдөх “Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн стандарт загвар” боловсруулагдаж байгаа.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Карьер өсөлтийн судалгаа
- Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ /ӨҮТ-ийн хүснэгт 7.2/
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ /ӨҮТ-ийн хүснэгт 7.3/
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2019 онд тэнхимийн 60 жилийн ой болсон. Энэ ойн хүрээнд зохион байгуулсан ажлуудын үр дүнд төгсөгчид, ажил олгогчид болон бусад оролцогч талын хамтын ажиллагаа хөгжих нөхцөл бүрдсэн.
- Хөтөлбөрийн үр дүнгийн талаар суралцагчид болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчид болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд суурилсан мөшгөх үйл ажиллагаа тогтмолжоогүй.

Зөвлөмж:

- Суралцагчид болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийн үр дүнгийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийдэг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Тэнхимийн багш нар мэргэжлийн холбоодуудтай хамтарсан ажлын тайлан
- Ажил олгогчидтой хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

(Тэмдэглэл: ӨҮ-ний баг “хэсэгчлэн хангасан” гэсэн үнэлгээ өгсөн.)

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг.
- 1996 оноос тус хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.
- Үндэсний магадлан итгэмжлэл хийлгэх ажил процессын дагуу явагдаж байна.
- Олон улсад магадлан итгэмжлэл хийлгэхээр төлөвлөсөн.

Анхаарах асуудал:

- Шинжээчийн баг сургууль дээр очиж ажиллах үед нотлох баримт эмх цэгцтэй бус байсан нь ажиллахад хүндрэлтэй байсан. Иймд дараагийн удаа магадлан итгэмжлэлд орохдоо нотлох баримт, баримт бичгийн эмх цэгцэд анхаарах

Зөвлөмж:

- ӨҮТ-д тусгасан засаж сайжруулах, хийхээр төлөвлөсөн ажлуудаа цаг алдалгүй хийж эхлэх;
- Нотлох баримт, баримт бичгийн эмх цэгцэд цаашид анхаарч ажиллах;

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетингийн магистрын хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохин байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	2			
6	Багшлах бүрэлдэхүүн	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Маркетинг” /E04140101/ магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Ч.Наранчимэг

Шинжээчийн багийн гишүүн: Дам.Ганбаатар

Шинжээчийн багийн гишүүн: Даян.Ганбаатар

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	МУИС-ийн Бизнесийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Маркетингийн магистрын хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс	E04140101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөр тасралтгүй сайжрах тогтолцоог бий болгох. Үүний тулд хэрэгцээг зөв тодорхойлох механизмтай болох; • Өөр мэргэжлийн оюутан тус хөтөлбөрөөр суралцахаар элссэн тохиолдолд маркетингийн суурь ойлголт олгох хичээлийг урьдчилан судлах боломжийг олгосон сургалтын журмын заалтыг хэрэгжүүлэх; • Ажил олгогчоос төгсөгчдийн ур чадварыг тодорхойлох судалгаа авч, үр дүнг хөтөлбөрт тусгах, улмаар энэ үйл явцыг тогтмолжуулж, хэвшмэл үйл ажиллагаа болгох; • Хөтөлбөрийн хүрээнд ордог бүх хичээлийн хөтөлбөрөөр электрон эсвэл хэвлэмэл хэлбэрээр “Хичээлийн хөтөлбөрийн тэнхимийн сан” бүрдүүлэх;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Тухайн хичээлд ашиглах программуудын жагсаалтыг гаргаж, хичээлийн хөтөлбөрт тусгах;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	<ul style="list-style-type: none"> • Сургалтын онцлогт нийцсэн, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн анги танхимын загварыг гаргаж шинээр баригдахаар төлөвлөж байгаа байрны зураг төсөлд эртнээс тусгах, анги танхим лабораторийн орчныг олон улсын жишиг, орчин үетэй нийцүүлэх тал дээр анхаарах; • МУИС-ийн төв номын сангийн байранд байрладаг БС-ийн дадлагын бааз буюу Нийгмийн судалгааны хүрээлэн, Дата лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлэх, боломжтой бол шинээр баригдах хичээлийн 4-р байранд орчин үеийн маркетингийн чиглэлийн бие даасан судалгааны лабораторитой болох; • Сургалтад ашигладаг монгол сурах бичгийн тоог нэмэгдүүлэх;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Сургалтын чанарыг сайжруулах үйл явцад ажил олгогч талын оролцоог нэмэгдүүлэх; • Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; • Тэнхимийн мэдээллийн сан буюу дата санг бүрдүүлэх. Тухайлбал, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, үр дүн, хамрагдсан хүний тоо зэргийг тухай бүр бүртгэлжүүлж хэвших; • Төсөвтэй холбоотой тэнхимийн мэдээллийн сан буюу дата санг бүрдүүлэх. Үүнд: төсвийн саналын бүрдэл, түүний нийт дүн, батлагдсан төсөв, түүний нийт дүн, гүйцэтгэлийн задаргаа,

	<p>түүний нийт дүн зэргээр дата сан бүрдүүлэх, тодорхой хугацаанд дата сангаа баяжуулдаг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох;</p> <ul style="list-style-type: none"> • Алба нэгжийн удирдлага төсвийн санал, батлагдсан төсөв, гүйцэтгэл зэрэгт тайлант хугацаа бүрд дүн шинжилгээ хийдэг, санхүүгийн төлөвлөлтийн үр дүнгээ үнэлдэг болох;
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн магистрантуудаас сүүлийн жилүүдэд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй шалтгааныг тодруулах, улмаар тэтгэлэгт хамрагдах боломж нөхцөлийг судлан, мэдээллийн хүртээмжийг сайжруулах;
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Багш нарын ачааллыг бууруулах, хүний нөөцийн талаарх асуудлыг бодлогын түвшинд анхаарч, хэрхэн шийдэх гарц шийдлийг үе шаттайгаар тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; • Багшийн хөгжлийн хөтөлбөрт нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг тусгаж, шинэчлэн боловсруулах саналыг холбогдох алба нэгжид хүргэх;
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Суралцагчид болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийн үр дүнгийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийдэг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох. • ӨҮТ-д тусгасан засаж сайжруулах, хийхээр төлөвлөсөн ажлуудаа цаг алдалгүй хийж эхлэх; • Нотлох баримт, баримт бичгийн эмх цэгцэд анхаарч ажиллах;

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Я.Отгонсүрэн	Профессор, зөвлөх багш	PhD	44	<ul style="list-style-type: none">• Маркетингийн удирдлагын бодлого стратеги• Байгууллага хоорондын харилцааны маркетингийн удирдлага
2	Б.Даваасүрэн	Профессор	PhD	26	<ul style="list-style-type: none">• Хэрэглэгчийн зах зээлийн удирдлага• Олон улсын бизнес маркетингийн стратеги
3	С.Бурмаа	Дэд профессор	PhD	26	<ul style="list-style-type: none">• Бүтээгдэхүүний удирдлага• Хуваарилалтын сувгийн удирдлага• Стратегийн маркетинг
4	Г.Урандэлгэр	Ахлах багш	PhD	4	<ul style="list-style-type: none">• Стратегийн маркетинг• Олон нийтийн харилцааны удирдлага

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	М.Бат-Оргил	2	Голч оноо
2	А.Болорчимэг	1	Голч оноо
3	Б.Өлзийболор	1	Голч оноо
4	Ж.Оюунтөгс	1	Голч оноо
5	Н.Цогтбаяр	1	Голч оноо
6	Б.Амгалан	2	Төгсөгч
7	Т.Ариунсайхан	1	Голч оноо
8	Б.Замилан	2	Голч оноо
9	Н.Мөлдир	1	Төгсөгч
10	Т.Наранцацрал	2	Төгсөгч
11	Ш.Сэнгүм	2	Голч оноо
12	Г.Төгөлдөр	2	Голч оноо

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Д.Амгаланбаатар	ММСГ	Ерөнхий захирал
2	С.Энхтуяа	Мандах ИС	Захирлын ажлын албаны дарга
3	С.Бадарч	ХААИС, ЭЗБС	Маркетингийн тэнхимийн зөвлөх профессор
4	Э.Тогтуун	Анд Системс	Хамтын ажиллагааны дарга
5	Н.Пүрэвцогт	МУИС, Хөтөлбөрийн Чанарын Баталгаажилтын Хэлтэс /ХЧБХ/	Хөтөлбөрийн Чанарын Баталгаажилтын Хэлтэсийн дарга
6	М.Эрдэнэчимэг	МУИС-ийн Оюутан Төгсөгчдийн Хэлтэс	Оюутан Төгсөгчдийн Хэлтэсийн дарга
7	Б.Мөнхнаран	Тэнхлэг зууч	Ерөнхий захирал
8	Б.Нармандах	UBS TV	Дэд захирал
9	Х.Тунгалагмаа	Монгол тах ТМЗ	ТУЗ-ийн дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Сайнжаргал	2010	Мандах ИС	багш
2	Б.Тогтуун	2015	Анд системс, Хамтын ажиллагааны алба	Хамтын ажиллагааны менежер
3	Н.Алтанзул	2015	Монгол тах ТМЗ	Гүйцэтгэх захирал
4	Д.Бат-Ундрал	2016	МУИС, Хөтөлбөрийн Чанарын Баталгаажилтын Хэлтэс /ХЧБХ/	Мэргэжилтэн
5	С.Долгорсүрэн	2016	ММСГ	Хэлтсийн дарга
6	Б.Баттүвшин	2016	ХААИС-ийн БЭЗС	багш
7	Б.Жамъянхорол	2016	Капитрон банк	Бизнес хөгжлийн хэлтсийн захирал
8	Ч.Батбааатар	2011	МУИС-ийн БС	багш
9	Б.Угтахжаргал	2012	МУИС-ийн БС	багш
10	П.Түвшинмандах	2019	ММСГ	Албаны дарга
11	Д.Болормаа	2011	Berlin-Chemie эмийн компани	Бүсийн төлөөлөгч
12	О.Энхжин	2019	Хаан даатгал	Даатгалын газрын захирал
13	Г.Соёлмаа	2016	СХД-ийн 117-р цэцэрлэг	нягтлан
14	Г.Батсайхан	2017	UBS TV	Ерөнхий менежер
15	Л.Чинзориг	2017	МУИС-ийн Оюутан Төгсөгчдийн Хэлтэс	Оюутны үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
16	Д.Должинсүрэн	2012	Тэнхлэг зууч	Захирал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/


МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ
14201 Улаанбаатар хот-4ба ш/х-460, Сүхбаатар дүүрэг,
Баян тойруу 4, Утас/Факс: (976-11) 35-09-94,
E-mail: bs@msu.edu.mn, http://bs.msu.edu.mn

2021. 01. 11 № 8/08
танай _____ -ны № _____ -т

Шинжээчдийн дүгнэлтэд
хариу хүргүүлэх тухай

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Маркетинг, Худалдааны тэнхимд хэрэгждэг "Маркетинг" магистрын сургалтын хөтөлбөр (E04140101 индекстэй)-ийн өөрийн үнэлгээний тайланд шинжилгээ хийх мэргэжлийн шинжээчдийн багаас ирүүлсэн 30 хуудас бүхий тайлан дүгнэлтийг 2021 оны 01 сарын 08-ны өдөр хүлээн авч танилцлаа.

Тайланд дурдагдсан хөтөлбөрийн ололт амжилттай талуудыг улам бүр бататгаж, хөтөлбөрийг сайжруулан чанаржуулахад анхаарвал зохих зөвлөмжүүдийг хэрэгжүүлэгч тэнхим анхааралдаа авч, тус сургуулийн холбогдох алба нэгжүүдэд хүргүүлэн цаашдын ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажиллах болно.

Магистрын хөтөлбөрийн өөрийн үнэлгээ хийхэд хамтран ажилласан БМИУЗ-ийн хамт олонд болон шинжээчийн багт талархлаа илэрхийлье.

ЗАХИРАЛ  Ч.ЭНХБАЯР

YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/